



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
А.АРИУНЗАЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020. 11. 27 № 37

Асуулга тавих тухай


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Танд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар дараах хүрээнд асуулга тавьж байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлд хийгдсэн болон хийхээр төлөвлөгдөж буй ажлуудын талаар;
2. Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсч буй нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай зохицуулалтуудын талаар;
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих чиглэлээр хийгдсэн болон цаашид хийхээр төлөвлөж буй ажлуудын талаар;
4. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн төлөв байдал, цаашид баримтлах бодлогын талаар;
5. Ажил хайгч, ажилтан, ажил олгогчид тус бүрийн нийтлэг зан төлөв, түүнд гарч буй өөрчлөлт, чиг хандлагын талаар;
6. Ажилд ороход хүндрэлтэй иргэд, малчид, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон нөхөрлөл, хоршоодыг дэмжих чиглэлээр хийгдсэн болон цаашид хийхээр төлөвлөгдөж буй ажлуудын талаар;
7. Ажил олгогчдыг дэмжих чиглэлээр хийгдсэн болон цаашид хийхээр төлөвлөгдсөн ажлуудын талаар;
8. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, сүлжээний үйл ажиллагааны өнөөгийн байдал, үр дүн, цаашид хөгжүүлэх төлөвлөгөө, сайжруулах шаардлагатай зохицуулалтын талаар;
9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа, өнгөрсөн хугацаанд хүрсэн үр дүн, цаашдын төлөвлөгөөний талаар;
10. Үйл ажиллагаа явуулж буй хөдөлмөрийн биржүүдийн мэдээлэл, өнгөрсөн хугацааны ажлын үр дүнгийн талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2020000084